

ТОЙМ



**ОЛОН УЛСЫН
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

2024.06.10

Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- G7 улсуудаас Канадын төв банк анх удаа хүүгээ 0.25 нэгжээр бууруулж 4.75 нэгж хувьд хүргэлээ.
- Европын Төв банк бодлогын хүүгээ 25 суурь нэгжээр бууруулж 3.75 хувь болголоо.
- NVIDIA компани зах зээлийн үнэлгээгээрээ 3 их наяд долларын босгыг давлаа.
- БНХАУ-д төмрийн хүдрийн эрэлт буурч, ханш сүүлийн зургаан долоон хоногийн доод түвшинд хүрээд байна. Хятадын үл хөдлөх хөрөнгийн салбарын хямрал нь түүхий эдийн эрэлтэд сөргөөр нөлөөлж байна.

2024 он 6-р сарын 10

Dow Jones	38,798.99
S&P 500	5,346.99
Nasdaq	17,129.90
DAX	18,555.39
FTSE 100	8,245.37
S&P/ASX 200	7,860.00
HANG SENG	18,366.95

АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	-0.22%	0.59%	-1.81%	2.94%	14.53%	12.53%
S&P 500	-0.11%	1.20%	2.38%	12.10%	24.38%	25.89%
Nasdaq	-0.25%	1.79%	4.83%	14.11%	29.19%	21.75%
2024 оны 6 сарын 10-ны 10:30						



Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	-0.52%	-0.28%	-1.16%	10.77%	16.34%	18.24%
FTSE 100	-0.48%	-0.21%	-2.23%	6.62%	9.03%	15.58%
2024 оны 6 сарын 10-ны 10:30						



Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	0.49%	1.28%	1.43%	3.55%	10.35%	7.49%
Hang Seng	-0.59%	-0.20%	-3.15%	7.74%	-5.28%	-36.32%
2024 оны 6 сарын 3-ны 16:30						





Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Аж үйлдвэрийн салбар уналттай ч үйлчилгээний салбар өсөлттэй байна:

S&P 500 болон Nasdaq Composite индексүүд бүх цаг үеийн дээд ханшиндаа хүрсэн боловч DJIA индекс уналттай байлаа. Түүнчлэн АНУ-ын аж үйлдвэрийн PMI индекс 48.7-д хүрсэн буюу уналтын бүсэд оржээ.

Лхагва гарагт мэдээлсэнээр АНУ-д хувийн хэвшлийн салбарын шинэ ажлын байрны тоо 152,000 болж буурсан нь сүүлийн 4 сарын хамгийн доод түвшин боллоо. Үүнтэй зэрэгцэн ажилгүйдлийн түвшин 3.9 хувиас өсөж 4 хувьтай гарсан нь эдийн засаг цаашид тогтворуй байна гэсэн хүлээлтийг нэмэгдүүлээд байгаа юм.

S&P500 дахь компаниудын 61 хувь нь ашгийн хүлээлтээ давжээ:

Тайлангаа зарласан компаниудын 61 хувь нь ашгийн хүлээлтээ давсан байгаа ч энэ нь 5 жилийн дундаж 69 хувиасаа бага байна. Тэр дундаа үл хөдлөхийн салбарын компаниудын 74 хувь нь ашгийн хүлээлтээ давсан бол хэрэглээний салбарын компаниудын 33 хувь нь ашгийн хүлээлтээ давуулсан байна.

Мөн Nvidia компани зах зээлийн үнэлгээгээрээ 3 их наяд ам.долларын босгыг давсан нь анхаарал хандуулахуйц үйл явдал боллоо. Тус компани өнгөрсөн баасан гарагт арилжааны цаг хаагдсаны дараа хувьцаагаа 1:10 харьцаатайгаар хуваасан бөгөөд хувьцаа хуваахаас өмнөх долоо хоногт 10.27 хувиар өсөөд байсан билээ.

Техникийн хувьд индексүүд 3-6 орчим хувийн өсөлт үзүүлээд зогсож магадгүй:

2024 оны 1-р улирлын дунд үеэс хойш хувьцааны арилжааны идэвх буурч байгаа ба ялангуяа сүүлийн үеүдэд эрчимтэй буурсан байна. Шижээчдийн үзэж байгаагаар ханш 5,490 түвшин дээр очих магадлалтай байгаа ба үүний дараа дунд хугацааны уналтыг таамаглаж байгаа юм. Ханшийн хөдөлгөөнийг илэрхийлэгч гол бүсүүд болон индикаторуудын зааж буйгаар өсөлтийн тренд тогтвортой бус байна. Гэсэн хэдий ч одоогийн байдлаар өсөлтийн тренд үргэлжилсээр байгаа юм.

График 1: АНУ-ын S&P500 индекс ба техник шинжилгээ





Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

БНХАУ-ЫН ЗАХ ЗЭЭЛ

Үл хөдлөхийн салбарын үзүүлэлтүүдийг 2023 оны үзүүлэлтийг давж чадахгүй байна: China Real Estate Information Corp. 5-р сард БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн TOP 100 хөгжүүлэгчийн борлуулалтын дүн 11.5 хувиар өссөнийг мэдээлжээ. Гэсэн хэдий ч өнгөрсөн сарын хувьд шинэ үл хөдлөхийн борлуулалт өнгөрсөн жилийнхтэй харьцуулбал 33.6 хувь буураад байна.

Цахилгаан автомашинаа эргэн дэмжиж эхлэв: БНХАУ-ын Засгийн газар 4-р сарын сүүлээр энгийн түлш хэрэглэдэг автомашиныг цахилгаан автомашинаар солих тохиолдолд 10 мянган юань буюу 1,380 ам.долларын хөнгөлөлт эдлүүлэх дэмжлэгийн хөтөлбөрийг зарласнаар Хятадын цахилгаан автомашин үйлдвэрлэгч Nio, Xpeng болон Li Auto нарын ирэх улирлын борлуулалтын орлогын төсөөллийг өсгөлөө.

Хятад улсын Засгийн засгийн газар цахилгаан автомашины салбарын дэмжлэгийг 2009 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2014 онд л гэхэд цахилгаан автомашин худалдан авахад 100,000 юанийн хөнгөлөлт үзүүлж байсан удаатай.

Үүнээс гадна, Европын Холбооноос БНХАУ-г цахилгаан автомашины үйлдвэрлэлтэй холбоотойгоор гадаад худалдаандаа протекционизм буюу дотоодын зах зээлийг бусад орны үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнээс тусгаарлах оролдлого хийсэн хэмээн шалгаж байна.

График 2: Цахилгаан автомашин үйлдвэрлэгчдийн хувьцааны ханшийн динамик



Түүнчлэн, 5-р сард АНУ тус улсаас импортлож буй хагас дамжуулагч, цахилгаан автомашин, ган болон батарей зэрэг бараануудын хувьд тарифын хязгаарлалт хийгээд байна. Үүнтэй холбоотойгоор, 5-р сард аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 0.9-өөр буурч 49.5 хүрсэн байна.

